

ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3-р сарын 28-ны өдөр

Дугаар 67

Улаанбаатар хот

ДАРХЛААЖУУЛАЛТЫН ТАЛААР АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Дархлаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь :

1. Дархлаажуулалтын сан байгуулж, уг сангийн ажиллах журмыг 1 дүгээр, “Сангийн зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм”-ийг 2 дугаар, “Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээний жагсаалт, тарилгын товлол”-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Дархлаажуулалтын санд зохих хөрөнгийг төвлөрүүлэх, сэргийлэх тарилгыг зохион байгуулахтай холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Эрүүл мэндийн сайд П.НЯМДАВАА

ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дархлаажуулалтын тусгай сан /цаашид “сан” гэнэ/ байгуулах, түүний хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах зэрэг үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Дархлаажуулалтыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, хөрөнгийн хуримтлал бий болгох зорилго бүхий уг сангийн хөрөнгийг халдварт өвчнөөс сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, тархвар судлалын заалтаар хийж байгаа сэргийлэх тарилга, зүү, тариур, эм, урвалж бодис худалдан авах, тээвэрлэх зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

3. Сан нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд тогтоосон журмын дагуу хийгдсэн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж болно.

4. Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу сангийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг Эрүүл мэндийн яам, шууд захирагчийн үүргийг сангийн зөвлөлийн зохицуулалтын дор Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

5. Сан байгуулах, үйл ажиллагаанд нь өөрчлөлт оруулах, санг татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

6. Сангийн хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

б/ өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж;

в/ гадаад орон, олон улсын болон сайн дурын байгууллагын хандив, тусламж;

г/ сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилгын төлбөр;

д/ бусад эх үүсвэр.

7. Дархлаажуулалтын арга хэмжээнд тухайн санхүүгийн жилд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн яамны саналыг үндэслэн Санхүү, эдийн засгийн яам улсын төвлөрсөн төсөвт тусгана.

8. Санхүү, эдийн засгийн яам нь улсын төвлөрсөн төсвөөс энэ дүрмийн 7-д заасан арга хэмжээнд зориулан олгох хөрөнгийг тус сангийн дансанд саадгүй шилжүүлэх, сангийн эрх захирагчийн төлбөрийн даалгаврыг үндэслэн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу сангийн зарцуулалтын байдалд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээнэ.

9. Сангийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийн тайланг Санхүү, эдийн засгийн яаманд гарган өгч, үлдэгдлийг баталгаажуулан дараа жилийн үйл ажиллагаанд шилжүүлэн зарцуулна.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

10. Сангийн хөрөнгийг урьдчилан сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, зүү, тариур, сэргийлэх бусад эм, урвалж худалдан авах, тэдгээрийг тээвэрлэх, түгээх зориулалтаар сангийн зөвлөлийн зөвшөөрсөн хэмжээгээр Халдварт өвчин судлалын үндэсний төв захиран зарцуулна.

11. Энэ дүрмийн 10-т заасныг үндэслэн Халдварт өвчин судлалын үндэсний төв нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/улсын хэмжээнд хэрэглэгдэх вакцин, биобэлдмэл, зүү, тариурын нэгдсэн захиалга болон шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж, жилд 2–оос доошгүй удаа сангийн зөвлөлд танилцуулна;

б/сангийн хөрөнгөөр худалдан авах вакцин, зүү, тариур, биобэлдмэл, эм, урвалжийн үнийн болон тэдгээрийг нийлүүлэх, тээвэрлэх гэрээний нөхцөлийн талаар сангийн зөвлөл болон Эрүүл мэндийн яамтай урьдчилан зөвшилцөнө; в/вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллана;

г/стандартын шаардлагад бүрэн нийцсэн, чанарын баталгаатай вакцин, биобэлдмэлээр хангах арга хэмжээ авч, тэдгээрийн тээвэрлэлт, хадгалалт, орон нутагт хүргэх үеийн хадгалалтын горимыг чанд мөрдөнө;

д/вакцин, биобэлдмэл, зүү, тариурын болон хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн үнэ, тээврийн зардлыг нийлүүлэгч болон тухайн ажлыг гүйцэтгэгч байгууллагын нэхэмжлэл, гүйцэтгэлийн тухай албан ёсны бичиг баримтыг үндэслэн зөвхөн дансаар шилжүүлнэ;

е/сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан тэнцлийг улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа тайлан тэнцлийн маягтын дагуу улирал, жилээр гарган сангийн зөвлөлд танилцуулна.

Дөрөв. Сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилгын төлбөрийн зохицуулалт

12. Энэ дүрмийн 6-гийн “г”-д заасны дагуу сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилга /цаашид “сэргийлэх тарилга” гэнэ/-ын төлбөрийг сангийн дансанд оруулна.

13. Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажиллагчдыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээж, тухайн жилд уг тарилгад хамрагдвал зохих хүмүүсийн судалгааг сэргийлэх тарилга тус бүрээр гаргаж хамрах хүрээний эмнэлэг, эрүүл мэндийн газарт жил бүрийн 1 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ.

14. Тарваган тахал өвчний голомт бүхий нутгийн малчдын сэргийлэх тарилгын төлбөрийг дархлаажуулалтын сангаас хариуцна.

15. Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй ажилтны “В” гепатит, балнад, боом, шар чичрэг, урвах тахлын дархлаажуулалтын зардлыг тухайн ажилтныг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь, ийм төрлийн ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч төлбөрөө өөрөө хариуцна.

Тав. Хяналт, хариуцлага

16. Сангийн хөрөнгөөр худалдан авсан вакцин, биобэлдмэл, зүү, тариурын чанар, хуваарилалт, хадгалалтад Эрүүл мэндийн улсын хяналтын алба болон холбогдох бусад байгууллага хяналт тавина.

17. Сангийн хөрөнгийг энэ дүрэмд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

18. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан буюу энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----оОо----

ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дархлаажуулалтын сангийн орон тооны бус зөвлөл /цаашид "зөвлөл" гэнэ/-ийн үйл ажиллагааг энэ дүрмээр зохицуулна.

2. Зөвлөл нь Монгол Улсын дархлаажуулалтын тухай хууль болон дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд дархлаажуулалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон удирдамж, зөвлөмж гаргах, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, зарим халдварт өвчнийг тууштай бууруулах, устгах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу хуваарилах, түүний зарцуулалтад хяналт тавих үүрэгтэйгээр ажиллана.

3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан Эрүүл мэндийн болон Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар батална.

4. Зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулна. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн гаргана. Зөвлөлийн ээлжит бус хурлыг шаардлагатай үед зарлан хуралдуулж болно.

5. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

6. Зөвлөл нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх ба зөвлөлийн хурлаас тогтоол, удирдамж, зөвлөмж гаргана.

7. Зөвлөл нь хурлаараа сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр хэлэлцэж, дүгнэлт өгөх ба сангийн хөрөнгийг хуваарилах болон дархлаажуулалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, зохион байгуулалтын асуудлаар холбогдох шийдвэр гаргана.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

8. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулахтай холбогдсон асуудлаар шийдвэр гаргах;

б/жил бүрийн улсын төвлөрсөн төсвөөс Дархлаажуулалтын санд олгох хөрөнгийн талаар эрүүл мэндийн болон санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, зөвлөмж гаргах;

в/сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай бол энэ асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагад санал гаргах;

г/сан бүрдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын идэвхтэй оролцоог хангах;

д/сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

е/сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад аудитын байгууллагаар шалгалт хийлгэх, дутагдал илэрсэн нөхцөлд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

ж/сангаас санхүүжүүлэн нийлүүлэх вакцин, биобэлдмэлийн үнэ тарифын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал оруулах.

9. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/сангийн үйл ажиллагааны тайлан, дархлаажуулалтын үр дүнгийн талаархи мэдээлэл, судалгааг холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоосон хугацаанд гаргуулан авах;

б/сонгон шалгаруулалтаар нийлүүлэхээр төлөвлөгдөж байгаа вакцин, биобэлдмэлийн чанар, үнийн санал, ерөнхий нөхцөлийн талаар холбогдох байгууллагуудад хандсан зөвлөмж гаргах, чиглэл өгөх;

в/сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг томилон ажиллуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар чиглэл, үүрэг даалгавар өгөх;

г/сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан байгууллага, иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал гаргах.

----oOo----

СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДАХ ШААРДЛАГАТАЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ТАРИЛГЫН ТОВЛОЛ

	1.Тарваган тахлын вакцинд:	-Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах байгууллагын бүх ажиллагчид; Уг сэргийлэх тарилгыг жил бүрийн 5-6 дугаар сард 1 удаа хийлгэнэ.
-Тарваган тахлын байгалийн идэвхтэй голомтот нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид; 2. “В” гепатитын вакцинд:	-Тарваган тахлын байгалийн идэвхтэй голомтот нутгийн анчин, тууварчин, жолооч. -Мэс засал, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, сувилагч; Уг сэргийлэх тарилгыг нэг удаа, 2 тунг нэг сарын зайтай хийлгэнэ.	-Шүдний их эмч, сувилагч, техникч;
-Лабораторийн эмч, лаборант;	3. Боомын вакцинд:	3. Балнадын вакцинд:
-Халдвартын эмнэлэг, тасгийн гэдэсний халдвартай өвчтөнтэй ажиллах хэсгийн эмч, сувилагч;	-Бохир ус цэвэрлэх байгууламжийн слесарь, механик;	-Орон сууц болон албан байгууллага, аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны слесарь, үйлчлэгч. -Малын их, бага эмч, амьтан маллагч;
Уг сэргийлэх тарилгыг хоёр жилд 1 удаа, 4-5 дугаар сард 10 хоногийн зайтай 2 удаа хийлгэнэ	4. Боомын вакцинд:	5. Шар чичрэгийн вакцинд:
-Мал, амьтны гаралтай түүхий эд /арьс, шир, ноос, ноолуур/ хүлээн авагч, бэлтгэгч, ийм чиглэлийн боловсруулах үйлдвэрийн хүлээн авах, анхан шатны боловсруулалт хийх дамжлагын ажилчин.	Уг сэргийлэх тарилгыг жил бүрийн 4 дүгээр сард 1 удаа хийлгэнэ.	
-Шар чичрэг өвчний голомт бүхий улсад ажиллах дипломат ажилтан, түүнтэй хамт амьдрах гэр бүлийн гишүүд. -Урвах тахал өвчний голомт бүхий улсад ажиллах дипломат ажилтан, түүнтэй хамт амьдрах гэр бүлийн гишүүд.+ .	Уг сэргийлэх тарилгыг тухайн улсад нэвтрэхээс 10 хоногийн өмнө 10 жилд 1 удаа хийлгэнэ. Анхны сэргийлэх тарилгыг тухайн улсад нэвтрэхээс 1 сарын өмнө, цаашид жил тутам 1 удаа хийлгэнэ	6. Урвах тахлын вакцинд: